

**МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2009 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН  
ЧИГЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

ХЭНТИЙ АЙМАГ

40242

д/д	Зорилт, арга хэмжээ	Биелэлт	биелэлт %
1	5.3. Өрхийн аж ахуйгаас бэлтгэсэн илүүдэл төмс, хүнсний ногоо, мах, сүү, цагаан идээ борлуулах татвар, түрээсийн төлбөргүй хүнсний зах, салбар, цэгүүдийг аймаг, сумын төв, нийслэлийн дүүрэг, хороодод байгуулж ажиллуулах	Өндөрхаан хотод хүнсний ногоо, мах, сүү, цагаан идээ борлуулах хүнсний 3 зах үйл ажиллагаа явуулж байгаа хэдий ч түрээсийн төлбөртэй ажиллаж байна.	30

2	<p>5.4. Нийслэл болон орон нутгийн томоохон хотуудад экологийн цэвэр сүү, цагаан идээ, мал болон гахай, тахианы мах, махан бүтээгдэхүүн, өндөгний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлж, “Сүү” хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж эхлэх</p>	<p>Улсын төсвийн төвлөрсөн хөрөнгө оруулалтаар барилдаж сууцны сүү боловсруулах хүчин чадалтай сүүний үйлдвэр нь барилгын засвар тохижилтын ажил дуусч, тоног төхөөрөмж суурилуулах ажил хийгдэж байна. Дадал, Хэрлэн суманд Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй Сүү” төслийн хүрээнд 5.9 сая төгрөгийн өртөгтэй хүүгүй, эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах тоног төхөөрөмжийг суурилуулан ашиглан байна. Хэрлэн суманд “Мах экспорт” ХХК-ний салбар махны анхан шатны боловсруулалт хийх үйлдвэр 2009 оны 8-р сараас үйл ажиллагаа нь эхлэн 3 сарын хугацаанд 250 гаруй тн махыг боловсруулаад байна. Шувууны аж ахуй эрхлэх 3 төсөлд 22.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон.</p>	100
3	<p>11.5. Газрын нэгдсэн төлөвлөгөөг Улсын Их Хурлаар батлуулж, нийслэл, аймгуудын төв болон төвлөрсөн суурингийн гэр хорооллыг барилгажуулахаас бусад газруудыг зөвхөн нээлттэй дуудлага худалдаагаар худалдах тогтолцоонд шилжих</p>	<p>Монгол улсын иргэнд газрыг нэг удаа үнэгүй өмчлүүлэх тухай хууль хэрэгжиж эхэлсэнээс хойш нийт өссөн дүнгээр 8515 өрх айл 1288.13 га газрыг үнэгүй газрыг өмчлүүлээд байна</p> <p>Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2007 оны 07 дугаар тогтоолоор үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар газрыг дуудлага худалдаа болон төсөл сонгон шалгаруулалтаар олгох байршил, хэмжээг тогтоож өгсөн бөгөөд аймгийн хэмжээнд нийт 2904 м2 газрыг худалдаа үйлчилгээний зориулалтаар олгож 27.7 сая, үр тарианы зориулалтаар 12204 га газрыг олгож 60.1 сая нийт 87.8 сая төгрөгийг орон нутгийн төсөвт оруулсан.</p>	100

4	11.7. Говь, хээр, цөлжилт ихээр явагдаж байгаа бүс нутгуудад усны нөөцийг нэмэгдүүлэх, мод, бут сөөг тарьж ургуулах ажлыг эрчимжүүлэх	Малчид иргэдийн оролцоотойгоор 2009 онд аймгийн хэмжээнд нийт 30 энгийн уурхайн худаг гаргаж 76000 га бэлчээрийг нэмж усжуулсан байна. Мөн Улсын төсвийн хөрөнгөөр Биндэр, Норовлин, Батноров, Батширээт сумдад нийт 4 булгийг эхийг хашиж хамгаалан нийт 6.0 сая төгрөгийг зарцууллаа. 2009 онд чацаргана, моносны 500 ширхэг суулгацыг Хэрлэн голын эрэг дагуу 2 га талбайд, ногоон байгууламж байгуулах зорилгоор 137 улиас 300 хайлаас мод бутыг тарьж суулгаад байна. 2009 онд 200 га-д ойжуулалт хийхээс 277 га талбайд ойжуулалт, 100га-д байгалийн сэргэн ургалтанд туслах ажлыг хийж улсын комисст 75,8%-ийн амьдралттайгаар хүлээлгэн өгсөнөөр төлөвлөгөөг 188.5%-иар биелэгдлээ. Уг ажилд нийт 49.5 сая төгрөг зарцуулагдсан.	90
5	11.7.1. Говь хээрийн бүсэд усан сан, хөв байгуулах, мод бут сөөг тарьж ургуулах ажлын үр дүнг сайжруулан арчилгаа, хамгаалалтыг сайжруулах	Нийт аймгийн хэмжээнд 2 хөв байгууллаа. Үүнд: Цэнхэрмандал суманд 2009 онд ХЯБХөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар 13.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хөв байгуулагдсан бол мөн сумын Түлүүгийн буланд 150.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий хөв байгуулах ажил хийгдэж байна. Ногоон хэрэм хөтөлбөрийн хүрээнд 5 га талбайд үндсэн зурвас байгуулах ажлын хүрээнд 1500 ширхэг хайлаас, улиангар, улиас модны тарьцыг суулгаж уг газрыг 33.7 сая төгрөгийн өртөгтэй 1080 м2 хайсаар хаших ажлыг хийлээ.	90

11.8. Говь, хээрийн цөлжилт ихээр явагдаж байгаа бүсүүдэд баянбүрд үүсгэх, худаг ус гаргах, усжуулах бүхий л санал, санаачилгыг дэмжиж, “Ус” хөтөлбөрийг үргэжлүүлэн хэрэгжүүлэх, хөдөөгийн баг бүрт сүүлийн үеийн дэвшилтэт технологийг ашиглан шинээр 1 худаг нэмж гаргах ажлыг

2009 онд улсын төвсийн хөрөнгө оруулалтаар бэлчээр усжуулах арга хэмжээнд зориулж 80 сая төгрөгөөр 5 суманд 6 худаг, ХЯБХ-ийн хөрөнгөөр 5 худаг гаргаж 45,5 мянган га бэлчээрийг усжууллаа. Хэрлэн суманд инженерийн хийцтэй худаг 1, Жаргалтхаан суманд богино яндант 2 худгийг иргэд өөрсдийн хүчээр засварлан ашиглаж байна. Хэрлэнбаян-Улаанд бэлчээрийг нэмж усжуулах, сайжруулах зорилгоор инженерийн хийцтэй 2 худгийг шинээр гаргаснаар аймгийн хэмжээнд нийт 16 худгийг шинээр гаргаад байна. Малчид иргэдийн оролцоотойгоор нийт 38 энгийн уурхайн худаг гаргаж 76,0 мянган га бэлчээрийг нэмж усжуулсан байна.

7	<p>14.16.1. Орон нутгийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийн тусгай зөвшөөрлийн шаардлагыг хэрхэн хангаж буйг судлан дүгнэлт гаргаж, орон нутгийн өмчөөс төрийн өмчид шилжүүлэх аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Төрийн өмчийн хорооны шийдвэр болон Засгийн газрын шийдвэр гаргах санал боловсруулах</p>	<p>2009 оны байдлаар аймгийн хэмжээнд 2 мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв ажиллаж байна. БСГ-аас тус сургуулиудын багш нарын үйл ажиллагаатай танилцан, арга зүйн зөвлөгөө өгч ажилласнаас гадна аймгийн МХГ-аас хяналт шалгалт хийхэд байгууллагын удирдлагын бүтэц зохион байгуулалт, сургалтын ажлын явц үр дүн, багшлах боловсон хүчний бүрэлдэхүүн хангалт, сургалтын орчин, суралцагчдад зориулсан нийгмийн үйлчилгээ сайн байсан ба иргэнд мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх, мэргэжлийн ур чадвар олгох, дээшлүүлэх сургалтыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчийн захиалгад нийцүүлэн сайн зохион байгуулж , хууль тогтоомжийн хэрэгжилт хангалттай гэж дүгнэгдсэн. Өндөрхаан хот дахь МСҮТ-ийн сургуулийн өргөтгөлд нийт 3.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж, 2009 онд барилгын ажилд 266.3 сая төгрөгийн санхүүжилт хийгдлээ.</p>	100
8	<p>15.13. Хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийг сайжруулах зорилгоор бүсийн болон аймаг, нийслэлд шүдний кабинет байгуулах ажлыг дэмжиж, хэрэгжүүлэх</p>	<p>цагаар тусламж үзүүлэх болсноор хүн амд хүрэх 2-догч шатлалын тусламж үйлчилгээний хүртээмж нэмэгдэж байна. Аймгийн Засаг даргын 304 тоот захирамжаар "Цацрал", "Wellness dent" шүдний үүдэн эмнэлгүүдэд шинээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгож, сургууль, цэцэрлэгийг хариуцуулан хүүхдийн шүдийг эрүүлжүүлэхээр хамтран ажиллаж байгаа нь үр дүнгээ өгсөн ажил боллоо. Сумдын эмнэлгүүд өөрсдийн зардлаар аймаг болон УБ хотоос шүдний нарийн мэргэжлийн эмч, багш нарыг 14 хоногоос 1 сарын хугацаатай ажиллуулснаар хүн амын дунд амны хөндийн эрүүл мэндийн тусламжийг цаг алдалгүй үзүүлдэг болсон. Жишээлбэл: Батноров сумын эмнэлэг нь УБ хотын Сонгино хайрхан дүүргийн Эрүүл мэндийн нэгдэлтэй хамтран ажилладаг ба шүдний эмчийг 2 удаа ажиллуулж нийт 640 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан 114 хүүхдийн амны хөндийг эрүүлжүүлсэн. Өмнөдэлгэр, Бэрх, Биндэр сумдын эмнэлгүүд шүдний сум дундын эмчийг орон тоогоор ажиллуулж байгаа ба ДЗОУБайгууллага нь Биндэр сумын эмнэлэгт шүдний эмчилгээний "Бор" машин суурилуулан зэргэлдээ болон өөрийн сумдын хүн амд тухайн тусламжийг үзүүлж байна.</p>	100

9	15.14. Сум, өрхийн эмчийг бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх тогтолцоо болон орон нутагт ажиллах эмч нарын урамшууллыг боловсронгуй болгох замаар анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмчийн хангалтыг сайжруулах	Сум, өрхийн эмч нарын мэдлэг ур чадварыг дээшлүүлэхээр төгсөлтийн дараахи сургалтанд хамруулж Жаргалтхаан сумын эмч мэдрэлийн чиглэлээр, Баян-Адрага сумын эмч хүүхдийн мэргэжлийн чиглэлээр тус тус суралцаж байна.Төрийн санхүүжилтээр нэн тэргүүнд шаардлагатай Бэрх сум дундын эмнэлэгт эмэгтэйчүүдийн их эмч бэлтгэж байна. Эмч нарын мэргэжлийг дээшлүүлэх зорилгоор богино хугацааны сургалтуудад нийт давхардсан тоогоор 150 гаруй эмч, мэргэжилтнүүд хамрагдсан. Энэ эмч нарын сургалтанд Баян-Адрага сумын эмч, Баян-Адрага сумын эмч нарын эмчийг томилон ажиллуулаа. 2007, 2008 онд төгсөж дадлагажигч эмчийн хугацаа нь дууссан 28 их эмчээс суманд 17, өрхийн эмнэлэгт 4, БГХӨСТ-д 1, УАУТ-д 1 эмчийг томилон ажиллуулснаар өрх, сумын эмнэлэгүүд их эмчээр 100 % хангагдлаа. 2009 оны төгсөлтөөс 3 багт багийн эмч хувиарласнаар хөдөөгийн 54 багаас 38 нь эмчээр хангагдаж. багийн эмчийн хангалт 70.3 хувь, нэгдсэн эмнэлэгийн их эмчийн хангалт 95.0 хувьтай байна.	100
10	15.17. Нийтийн биеийн тамир, спортын материаллаг баазыг өргөтгөхөд дэмжлэг үзүүлэх, нийтийн биеийн тамир, спортын талаар төрөөс баримтлах бодлогыг батлуулж, хэрэгжүүлж эхлэх	Монгол улсын ЗГ-ын 05 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд АЗДТГ, Хэрлэн сумын ЗДТГ, ДЗОУБ, ЭМГ, БТСХороо хамтран зохион байгуулсан нийтийг хамарсан 12 удаагийн арга хэмжээнд давхардсан тоогоор 145 байгууллагын 6423 иргэн хамрагдсан.Биеийн тамир спортын газрын бүтэц зохион байгуулалтыг шинэчлэн удирдлагын менежментийг сайжруулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллав.Тогтвортой амьжиргаа II төслийн санхүүжилтээр Баян-Адарга сумын ЕБС-ийн спорт заалны дээвэр засварлаж, Цэнхэрмандал, Жаргалтхаан, Баянхутаг сум өөрсдийн хүчээр ЕБС-ийн биеийн тамир, спортын болон наадмын талбайг тохижуулах ажил хийсэн.ЭМГазар 250.0, цэргийн штаб 200.0, БТСГазар 200.0, АЗДТГазар 141.0 , Хэрлэн сумын ЗДТГазар 131.0, Аймгийн Засаг дарга нийт 922.0 мянган төгрөгөөр спортын арга хэмжээг санхүүжүүлсэн.	100
	Дундаж хувь		92

Тамгын газрын дарга

А.Гантөмөр